



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



★ Статистик мэдээ хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа ★



Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан

Судалгааны зорилго:

Чингэлтэй дүүргийн статистикийн хэлтсийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг бүтээгдэхүүн, үйлчилгээний үзүүлэлтээр тодорхойлж, үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдсэн юм.

Судалгааны зорилт:

- Хэрэглээний хэв маяг
- Бүтээгдэхүүний сэтгэл ханамж
- Цахим хуудсанд өгч байгаа хэрэглэгчдийн сэтгэл ханамж
- Цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэдэг мэдээлэлд хэрэглэгчдийн өгч байгаа үнэлгээ
- Статистикийн бүтээгдэхүүний чанар зэргийг тодорхойлох нь судалгааны үндсэн зорилт юм.

2020 оны эхний хагас жилийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны асуулга /14 асуулгатай/- ыг боловсруулж иргэд, ААН байгууллагууд, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, жил, улирал, сарын мэдээ авдаг ААН байгууллагуудаас ихэвчлэн ямар үйлчилгээ авдаг, түүндээ сэтгэл ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, ажил үйлчилгээгээ сайжруулахаар энэхүү асуулгыг авсан.

Судалгааны арга зүй, түүвэрлэлт:


Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн сэтгэл ханамжийн судалгааг https://docs.google.com/forms/d/1Ok0sH-XHApWsA2tuOlXuOosl5wJfCt8K2NG_yA3Q9U/edit цахим хуудас ашиглан 2020 оны 5 дугаар сараас 6 дугаар сарын 10-ны хооронд тус хэлтсээс үйлчилгээ авч байгаа иргэд, ААН-ээс авсан.

Судалгааны үр дүн:

1. Судалгаанд нийт 71 иргэн, ААН оролцсон бөгөөд насны бүтцээр авч үзвэл 51.5 хувь нь 35-54 насны хүмүүс, 38.2 хувь 19-34 насны залуучууд, 10.3 хувь нь 55-аас дээш насны бүлгийн хүмүүс эдлээд байна.

График 1


Та хэдэн настай вэ ?



2. Жендэрийн харьцаагаар авч үзвэл судалгаанд оролцсон 71 иргэний 75 хувь нь эмэгтэй, 25 хувь нь эрэгтэй иргэд оролцсон байна.

График 2


Таны хүйс ?



3. Судалгаанд оролцсон иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 1 хувь нь суурь, 2.9 хувь нь бүрэн дунд, 69.1 хувь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, 23.5 хувь нь магистр, 2.9 хувь нь докторын зэрэгийн боловсролтой байна.

График 3


Таны боловсролын түвшин ?



4. Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар харахад 51.5 хувь нь ААН байгууллага, 30.9 хувь төрийн байгууллага, 5.9 хувь нь төрийн бус байгууллагад ажилладаг, 1.5 хувь нь оюутан, 10.3 хувь нь бусад төрлийн хөдөлмөр эрхэлдэг иргэд байна.

График 4


Хөдөлмөр эрхлэлтийн байдал



5. Та манай хэлтсээс болон цахим хуудаснаас статистик мэдээ, танилцуулга авч ашиглаж байсан уу гэсэн асуултанд нийт судалгаанд оролцсон иргэдийн 58.8 хувь нь тийм, 41.2 хувь нь үгүй гэж хариулсан байна.

График 5


Та манай хэлтсээс болон цахим хуудаснаас статистик мэдээ, танилцуулга авч ашиглаж байсан уу?



6. Та ихэвчлэн ямар статистик мэдээ авахыг хүсдэг вэ ?
- Нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн статистик мэдээ
 - Хүн амын судалгаа
 - Сар бүрийн танилцуулга
 - Хүн амын дундаж орлого, орлогын түвшин
 - Үр дүнтэй буюу үр дүнгээс хамаарсан шийд
 - Бүх төрлийн
 - Сонирхолтой статистикийн мэдээлэл
 - Эдийн засаг, бизнесийн орчин
 - Эдийн засгийн мэдээлэл

График 6


Та ихэвчлэн ямар төрлийн статистик мэдээ авахыг хүсдэг вэ?



7. Та Статистикийн хэлтсээс өөрийн хүссэн тоон мэдээллээ авч чаддаг уу гэсэн асуултанд 23.1% хувь нь тийм, 38.5 хувь тийм гэхдээ бүрэн биш, 38.5 хувь хүссэн тоон мэдээллээ авч чаддаггүй гэж хариулсан байна.

График 7


Та Статистикийн хэлтсээс өөрийн хүссэн тоон мэдээллээ авч чаддаг уу?



8. Судалгаанд оролцсон иргэдээс тоон мэдээллийг ямар хэлбэрээр авахыг хүсдэг талаар асуухад 97 хувь цахим хэлбэрээр, 3 хувь нь цаасан буюу хэвлэмэл хэлбэрээр авахыг хүсдэг байна.

График 8


Та тоон мэдээллийг ямар хэлбэрээр авахыг илүүд үздэг бэ?



9. Судалгаанд оролцсон иргэдээс Статистикаас гарч буй тоон мэдээний чанарт 16.7 хувь нь маш сайн, 39.4 хувь нь сайн, 24.2 хувь нь дунд, 1.5 хувь нь муу, 1.5 хувь нь маш муу, 16.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

График 9


та манай байгууллагын мэдээллийн чанарт үнэлгээ өгнө үү ?



10. Судалгаанд оролцсон иргэдийн 38.8 хувь нь www.ubstat.mn цахим хуудсанд байршуулсан танилцуулга, судалгааг авч хэрэглэдэггүй, 61.2 хувь нь танилцуулга судалгааг авч хэрэглэдэггүй гэсэн байна.

График 10


Та, www.ubstat.mn цахим хуудсанд байршуулсан Статистикийн танилцуулга, судалдгааг авч хэрэглэж байсан уу?



11. Чингэлтэй дүүргийн фэйсбүүк хуудсыг 31.8 хувь нь дагадаг, 68.2 хувь нь дагадаггүй гэсэн санал өгсөн байна.

График 11


Та "Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтэс" фэйсбүүк хуудсыг дагадаг уу?



12. Судалгаанд оролцсон иргэдээс 75 хувь нь Статистикийн хэлтсээс гаргадаг инфографик мэдээллүүд цогц бөгөөд сонирхолтой гэсэн байна, 25 хувь нь үгүй гэж хариулсан байна.

График 12


Хэлтсээс гаргадаг инфографик мэдээллүүд сонирхолтой бөгөөд цогц мэдээллийг хүргэж чадаж байна уу?



13. Статистикийн албан хаагчдын ёс зүйг дүгнэхэд 67.2 хувь нь сайн, 26.6 хувь нь дунд, 6.3 хувь нь муу гэсэн дүгнэлт өгсөн байна.

График 13

Та Статистикийн хэлтсийн албан хаагчдын ёс зүй, харилцааг дүгнэн хэлнэ үү ?




14. Судалгаанд оролцсон иргэдээс манай хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах талаар санал асуухад:

- Бодит тоон мэдээлэл дээр суурилсан цогц мэдээллээр хурдан шуурхай хангах
- Тоо мэдээлэлээ илүү задгай тавьж өгөх хэрэгтэй байна
- Мэдээлэл авдаг боловч эргэж ямар нэгэн мэдээлэл өгдөггүй

- Хангалттай сайн
- Иргэдэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх
- Баярлалаа
- Байхгүй
- Аль болох хэрэгтэй үнэн зөв мэдээллээр хангаж сошиалаар болон вебсайтаар түгээж байгаасай гэж хүсэх байна.
- Санал хүсэлт байхгүй. Боломжийн
- Цаашдын ажилд нь амжилт хүсэн ерөөе. Та нар мундаг шүү
- Ажлын амжилт өндөр хүсье гэх сэтгэгдлүүдийг давтан илгээсэн байна.

График 14

Танд манай хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах талаар санал хүсэлт байна уу?



Дүгнэлт

1. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 50-аас илүү хувь нь 35-54 насны хүмүүс байна. Мөн 18-аас доош насныхан статистик мэдээний талаар ойлголтгүй байгаа харагдаж байна.
2. Хүйсийн харьцааны хувьд статистик мэдээ хэрэглэгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд буюу 75 хувийг эзэлж байна.
3. Боловсролын түвшнээр авч үзвэл судалгаанд хамрагдсан буюу ААН байгууллагад ажиллаж байгаа нийт хүн амын 69.1 хувь дипломын дээд буюу бакалаврын боловсролтой байна.
4. Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтсээс мэдээ авч болон өгч хамтран ажиллаж байгаа ААН байгууллагийн өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 51.5 хувь хувийн хэвшлийн байгууллагууд байна.
5. Статистикийн хэлтсээс гарч байгаа тоон мэдээ, танилцуулга, судалгааг хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын 58.8 хувь нь танилцан ажил болон амьдралдаа ашиггладан байна.
6. ААН байгууллага болон иргэд ихэвчлэн Статистикийн хэлтсээс нийгэм эдийн засаг хөгжлийн мэдээ, хүн амын дундаж орлогын түвшин, эдийн засгийн мэдээлэл, хүн амын судалгааг ихэвчлэн авах сонирхолтой байдаг байна.
7. Судалгаанд оролцсон ААН болон иргэд Статистикийн хэлтсээс өөрийн хүссэн тоо мэдээ болон танилцуулгыг 23.1 хувь нь бүрэн авч, 38.5 хувь нь судалгаа авдаг ч бүрэн биш харин үлдсэн 38.5 хувь нь ямар ч тоон мэдээ авдаггүй гэсэн байна.
8. Статистик тоон мэдээ хэрэглэгчдийн 97 хувь танилцуулга, судалгаагаа цахим хэлбэрээр авахыг хүсдэг байна.
9. Статистикийн хэлтэстэй хамтран ажилладаг болон статистик мэдээ авдаг ААН байгууллага болон иргэд хэлтсийн мэдээлийн чанарт 16.7 хувь маш сайн, 39.4 хувь нь сайн, 24.2 хувь нь дунд, үлдсэн нь

мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс харахад 56.1 хувь ихэнхи хувь сайн буюу Статистикийн хэлтсээс гарч буй тоон мэдээлэлийн чанар сайн байгаа харагдаж байна.

10. Судалгаанд хамрагдсан нийт АНН, иргэд www.ubstat.mn буюу Нийслэлийн Статистикийн газрын цахим хуудсанд байрнуулсан судалгаа, танилцуулгийг 61.2 хувь ашигладаг байна.
11. Судалгаанд хамрагдсан нийт АНН, иргэдийн 68.2 хувь нь "Чингэлтэй дүүргийн Статистикийн хэлтэс" фэйсбүүк хуудсыг дагадаг буюу уг фэйсбүүк хуудаснаас хэрэгтэй мэдээ мэдээллээ авч ажилладаг байна.
12. Манай хэлтсээс гаргаж буй инфографик нь нийт хэрэглэгчдийн 75 хувьд ойлголжтой цогц мэдээ мэдээллийг хүргэж чаддаг байна.
13. Статистикийн хэлтсийн ёс зүй харилцааг дүгнэхэд 67.2 хувь нь сайн буюу харилцааны соёлтой зөв боловсон харьцдан гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна.
14. Хэлтсийн үйл ажиллагааг сайжруулах санал гомдол:
 - Бодит тоон мэдээлэл дээр суурилсан цогц мэдээллээр хурдан шуурхай хангах
 - Тоо мэдээллээ илүү задгай тавьж өгөх хэрэгтэй байна
 - Мэдээлэл авдаг боловч эргэж ямар нэгэн мэдээлэл өгдөггүй
 - Хангалттай сайн
 - Иргэдэд илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх
 - Баярлалаа
 - Байхгүй
 - Аль болох хэрэгтэй үнэн зөв мэдээллээр хангаж сошиалаар болон вебсайтаар түгээж байгаасай гэж хүсэх байна.
 - Санал хүсэлт байхгүй. Боломжийн
 - Цаашдын ажилд нь амжилт хүсэн ерөөе. Та нар мундаг шүү
 - Ажлын амжилт өндөр хүсье